



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 03 өдөр

Дугаар A/74

Улаанбаатар хот

Нийслэлийн оны шилдэг багш,
дасгалжуулагч, тамирчин, арга
зүйч шалгаруулах тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилт, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч шалгаруулах болзлын дагуу дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодоос шалгаруулан ирүүлсэн хүмүүсийн материал, ажлын үзүүлэлт, үр дүнг үнэлж дүгнэн Нийслэлийн 2014 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч нарыг сонгон шалгаруулсугай.

2. Нийслэлийн 2014 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчээр шалгарсан хүмүүсийг шагнах шагналын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд шаардагдах 1.800.000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үндсэн төсвийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500169